



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 4/28

Мөрөн сум

Комисс томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2024 оны 05 дүгээр сарын 22-ний өдөр Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар, "БРЕНД ТЕЧ БРИДЖ" -ХХК-ний хооронд байгуулсан ХЭАМСЗДТГ /20240202024/ дугаартай ажил гүйцэтгэх гэрээгээр Орон нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалттай "Мод усалгааны систем, нөөцийн сав" нийлүүлэх явцад байнгын хяналт хийх, хүлээн авах эрх бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Ш.Баасандорж Байгаль орчны улсын байцаагч

Гишүүдэд: Э.Балчиндорж "Цагаан толгой" багийн Засаг дарга.

Б.Бямбадорж Байгаль хамгаалагч

2. "БРЕНД ТЕЧ БРИДЖ" ХХК-ний хийж байгаа "Мод усалгааны систем, нөөцийн сав" -д техникийн тодорхойлолтод заасан стандартыг хэрэгжүүлж ажиллаж буй эсэхэд байнгын хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулж ажиллахыг комиссын нийт гишүүдэд үүрэг болгосугай.

3. "БРЕНД ТЕЧ БРИДЖ" ХХК-аас "Мод усалгааны систем, нөөцийн сав" -г хүлээн авахдаа гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн акт үйлдэн хүлээн авч үндсэн хөрөнгөнд бүртгэж авч ажиллахыг комиссын дарга(Ш.Баасандорж)-д үүрэг болгосугай

ДАРГА

Н.НАМЖИЛНОРОВ